

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ БАРИХ, ЗАСВАРЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь тусгай зориулалтын авто зам, замын байгууламж /цаашид авто зам, замын байгууламж гэх/-ийг нэгдсэн бодлоготойгоор төлөвлөх, барих, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах, засварлах, хяналт тавих талаар иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Авто замын тухай болон бусад хуульд энэ журмаас өөрөөр заасан бол тухайн хуулийг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журмыг эрх бүхий байгууллагаар батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

Хоёр. Авто зам, замын байгууламжийг барьж, ашиглахад тавигдах шаардлага

2.1. Авто зам, замын байгууламжийг авто зам, төмөр замын дунд болон урт хугацааны нэгдсэн бодлого, төлөвлөлт, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн чиг хандлага, стратегийн ач холбогдол бүхий орд газруудын байршил, тээвэрлэлтийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан барьж ашиглана.

2.2. Авто зам, замын байгууламжийг төлөвлөхдөө стратегийн ач холбогдол бүхий орд газраас үүсэх ачаа тээврийг нэн тэргүүнд харгалзан, техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааны дүгнэлтэд үндэслэж тухайн чиглэлд тусгай зориулалтын авто зам барьж ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.

2.3. Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, ашиглах, эзэмшихтэй холбоотой үйл ажиллагааг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2.4. Авто замын чиглэлийг тогтоохдоо тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын уул уурхай бүтээгдэхүүн тээвэрлэх чиглэл, хүсэлтийг харгалзан олон салаа зам гаргахгүй байхаар дундын ашиглалтын нэг гол замаар тээвэр хийх боломжийг бүрдүүлнэ.

2.5. Авто замын техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/, зураг төсөл боловсруулах, техник технологийн хяналт хийх, барих, засварлах болон тэдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг хөрөнгө оруулагч эсхүл эзэмшигч санхүүжүүлнэ.

2.6. Авто зам барих, ашиглахад “Авто замын тухай” хуулийн 18, 19, 20, 21, 23, 28 дугаар зүйлийг мөрдөж хэрэгжүүлнэ.

2.7. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг хатуу хучилттай авто замаар гүйцэтгэнэ.

Гурав. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

3.1. Авто зам, замын байгууламжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэй уялдуулан барьж ашиглах асуудлыг шийдвэрлэж, зохицуулна.

3.2. Авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ-ийн дүгнэлт, тухайн орон нутгийн удирдлагын саналд үндэслэн авто зам барих чиглэлийг тогтоон батална.

3.3. Авто зам барих, ашиглах, засварлах гэрээ /цаашид “гэрээ” гэх/-нд заасан хугацаанд батлагдсан чиглэлийн дагуу авто замын барилгын ажлыг эхлүүлээгүй эсвэл барилга угсралтын ажил нь зогссон тохиолдолд авто зам барьж, ашиглах хүсэлт гаргасан дараагийн хөрөнгө оруулагч тухайн авто замын чиглэлийг ашиглах эрхтэй.

3.4. Авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

3.5. Гэрээг тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч /цаашид “Эзэмшигч” гэх/-тэй байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин, гэрээний хэрэгжилтийг жил тутам дүгнэж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

3.6. Авто замыг Т-01 гэсэн дугаараас эхлэн бүртгэж, үндэсний авто замын сүлжээний бүртгэл мэдээллийн санд оруулан, замын нөхцөл байдлын талаар жил тутам нэмэлт баяжилтийг хийж байна.

3.7. Авто зам, замын байгууламжийг “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын дагуу улсын ашиглалтад хүлээн авах бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3.8. Авто замыг ашиглалтад авах акт гарсны дараа тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах бүтээгдэхүүн тээвэрлэлтийн гэрээ байгуулна.

3.9. Авто зам, замын байгууламжийг гэрээт хугацаандаа барьж ашиглалтад оруулаагүй, засварын ажлыг стандарт, норм дүрмийн дагуу тогтмол хийж ашиглалтын бэлэн байдлыг хангаагүй, байгаль орчин, орон нутгийн ард иргэдийн амьдрах орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөг арилгах талаар тавьсан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол авто зам барих, ашиглах, засварлах болон бүтээгдэхүүн тээвэрлэлтийн гэрээг цуцална.

Дөрөв. Авто зам, замын байгууламж эзэмшигчийн эрх, үүрэг

4.1. Авто замын ТЭЗҮ хийгдэж, замын чиглэл батлагдсны дараа тухайн авто зам барих, ашиглах, засварлах гэрээг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

4.2. Эзэмшигч нь гэрээнд заасан хугацаанд тухайн авто зам, замын байгууламжийг зураг төсөл, техникийн шаардлага, стандарт, норм дүрмийн дагуу барьж ашиглалтад оруулна.

4.3. Эзэмшигч нь тухайн авто замын дагуу байрлах уул уурхайн орд газруудаас үүсэх ачаа тээврийг Засгийн газраас тогтоосон тарифын дагуу төлбөрийг авч, уг авто замыг ашиглуулах үүрэгтэй.

4.4. Эзэмшигч нь тухайн авто замын арчлалт, засварын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж, стандарт, норм дүрмийн дагуу гүйцэтгүүлэх бөгөөд хөдөлгөөний аюулгүй болон тээвэрлэлтийн бэлэн байдлыг хангана.

4.5. Авто замаар нийтийн тээврийн хэрэгсэл зорчуулах асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд зам ашигласны төлбөрийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс хэтрэхгүй байна.

4.6. Эзэмшигч нь хатуу хучилттай авто зам барьж ашиглалтад оруулсны дараа уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

4.7. Эзэмшигч нь Гэрээний хугацаа дуусгавар болоход авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэн өгнө.

Тав. Авто зам, замын байгууламж барих, ашиглах, засварлах

5.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг магадлал хийсэн зураг төслийн дагуу замын барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.

5.2. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээгээр гүйцэтгүүлнэ.

5.3. Авто зам, замын байгууламжийг “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын дагуу Ажлын хэсэг дүгнэлт гарган улсын ашиглалтад хүлээн авч, тээвэрлэлт хийх зөвшөөрлийг гэрээ байгуулсны үндсэн дээр олгоно.

5.4. Авто зам, замын байгууламж барих, засварлах үед байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлт хийх ажлыг авто зам эзэмшигч хариуцна.

Зургаа. Хүлээх хариуцлага

6.1. Авто замыг төлөвлөх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, барих, засварлах, ашиглах, эзэмших үйл ажиллагааны талаар худал мэдээлэл өгсөн талууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн аливаа зөрчил нь Захиргааны, Эрүүгийн, Иргэний, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын, Зөрчлийн тухай болон бусад хуулийн заалтыг зөрчсөн эсэхийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу эрх бүхий хууль хяналтын байгууллага тогтоож, холбогдох хуулийн заалтаар хариуцлага оногдуулна.

6.3. Авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөл хангаагүйгээс байгууллага, иргэнд хохирол учирсан болохыг хууль хяналтын байгууллага тогтоосон бол эзэмшигч байгууллага уг хохирлыг хариуцан төлнө.